**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

# Өмнөговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ӨМА-2025/062/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Өмнөговь аймаг 2025 он

Өмнөговь дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор: Ж.Болормаа
Утас: 70533552 Цахим хаяг: bolormaaja@audit.gov.mn
Аудитор: Э.Жаргал
Утас: 70533552 Цахим хаяг: jargale@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2025.02.25 № 69

танай ______ -ны № ______ -т

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА Б.ДОЛЖИНСҮРЭН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 283 дугаар тогтоолоор ахмадын сувиллын барилгыг актлан, шинээр барилга бариулах ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр эхлүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Өмнөговь аймгийн хэмжээнд хэрэгжүүлж буй “Нутгийн дэм” хөтөлбөрийн хүрээнд байгууллагын албан хаагчдыг хамруулж 222,471.7 мянган төгрөгийн дэмжлэг, төрийн үйлчилгээний албан хаагчид орон нутгийн нэмэгдлийг 25 хувиар буюу 128,754.0 мянган төгрөгийн нэмэгдэл олгуулж нийгмийн асуудлыг шийдвэрлүүлсэн байна.

4625020171

F:\2.Бичиг хэрэг\2025он\СТА-н дүгнэлт\Төсөл.Docx

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 13 зорилтын хүрээнд 61 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 93 хувьтай дүгнүүлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ӨСӨХБАЯР

F:\2.Бичиг хэрэг\2025он\СТА-н дүгнэлт\Төсөл.Docx

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **140,153,432.63** | **129,670,463.56** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 21,241,600.00 | 25,241,600.00 |
| **312** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | 21,241,600.00 | 25,241,600.00 |
| **3121** | **Төгрөг** | 21,241,600.00 | 25,241,600.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 21,241,600.00 | 25,241,600.00 |
| **33** | **АВЛАГА** | 641,280.71 | 802,564.56 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 641,280.71 | 802,564.56 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 13,000,000.00 | - |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 13,000,000.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 105,270,551.92 | 103,626,299.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 2,245,000.00 | 3,745,000.00 |
| 35130 | Эм боох материал | 2,245,000.00 | 3,745,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 103,025,551.92 | 99,881,299.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,898,300.00 | 1,979,800.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 93,993,251.92 | 89,921,499.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 5,779,000.00 | 7,165,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | 460,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 355,000.00 | 355,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **952,720,102.19** | **1,056,624,942.10** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 952,720,102.19 | 1,056,624,942.10 |
| **392** | **Биет хөрөнгө** | 804,333,660.53 | 897,846,100.91 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 933,270,226.00 | 868,029,988.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (266,029,416.89) | (226,014,767.30) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 98,498,000.00 | 98,498,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (98,498,000.00) | (98,498,000.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 343,308,457.27 | 501,267,901.27 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (282,934,427.12) | (306,623,304.38) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 215,598,507.71 | 215,598,507.71 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (138,879,686.44) | (154,412,224.39) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 148,386,441.66 | 158,778,841.19 |
| 39301 | Программ хангамж | 31,014,640.00 | 44,014,640.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (22,628,198.34) | (25,235,798.81) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 140,000,000.00 | 140,000,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,092,873,534.82** | **1,186,295,405.66** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,092,873,534.82** | **1,186,295,405.66** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,092,873,534.82 | 1,186,295,405.66 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 952,451,564.01 | 952,451,564.01 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 140,421,970.81 | 233,843,841.65 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 140,421,970.81 | 140,421,970.81 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 93,421,870.84 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,092,873,534.82** | **1,186,295,405.66** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,356,327,284.60** | **3,905,002,358.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **90,698,755.60** | **249,559,444.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 90,698,755.60 | 249,559,444.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 55,489,000.00 | 105,769,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 55,489,000.00 | 105,769,000.00 |
| 120009 | Бусад орлого | 21,000,000.00 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө | 14,209,755.60 | 143,790,444.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,265,628,529.00** | **3,655,442,914.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,262,207,200.00 | 1,984,606,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,262,207,200.00 | 1,984,606,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,003,421,329.00 | 1,670,836,414.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 40,265,820.00 | 34,524,960.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 907,658,149.00 | 1,613,925,454.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 55,497,360.00 | 22,386,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,439,776,025.66** | **3,811,580,487.16** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,439,776,025.66** | **3,811,580,487.16** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,226,451,276.53 | 2,288,178,421.86 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,047,442,728.03 | 1,786,527,221.67 |
| 210101 | Үндсэн цалин | 611,662,158.99 | 733,938,573.88 |
| 210102 | Нэмэгдэл | 324,208,359.83 | 579,137,559.79 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 89,420,785.52 | 216,672,000.00 |
| 210104 | Урамшуулал | 22,151,423.69 | 256,779,088.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 129,733,437.70 | 222,630,182.47 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 88,225,129.37 | 151,340,851.62 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,390,663.54 | 17,885,610.76 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,363,610.92 | 8,942,857.38 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,071,075.23 | 8,892,231.93 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20,682,958.64 | 35,568,630.78 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 32,393,816.54 | 14,470,544.23 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,546,711.86 | 6,173,751.28 |
| 210302 | Түлш, халаалт | 22,219,601.68 | 6,661,385.95 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,627,503.00 | 1,635,407.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 72,627,519.88 | 74,717,069.40 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,436,050.00 | 24,467,360.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,266,000.00 | 19,672,256.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,773,399.08 | 3,554,800.48 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 268,500.00 | 120,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,669,810.00 | 7,595,300.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 44,213,760.80 | 19,307,352.92 |
| **2105** | **Нормативт зардал** | 23,172,740.00 | 73,173,100.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,262,425.00 | 917,340.00 |
| 210502 | Хоол, хүнс | 21,910,315.00 | 72,255,760.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 921,000.00 | 604,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 921,000.00 | 604,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,584,000.00 | 7,896,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,584,000.00 | 7,896,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 87,627,263.81 | 41,105,700.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 84,482,309.81 | 38,589,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 900,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 337,000.00 | 1,229,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 125,004.00 | 258,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 823,800.00 | 800,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 959,150.00 | 229,600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 830,948,770.57 | 67,054,604.09 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 734,578,417.00 | - |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 19,137,200.00 | - |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 77,233,153.57 | 67,054,604.09 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 213,324,749.13 | 1,523,402,065.30 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 168,745,176.00 | 1,478,841,710.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | - | 1,227,000,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 15,841,723.00 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 168,830,850.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 152,903,453.00 | 83,010,860.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 44,579,573.13 | 44,560,355.30 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 44,579,573.13 | 44,560,355.30 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(83,448,741.06)** | **93,421,870.84** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(83,448,741.06)** | **93,421,870.84** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан* /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,342,117,529.00** | **3,761,211,914.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **76,489,000.00** | **105,769,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 76,489,000.00 | 105,769,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 55,489,000.00 | 105,769,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 55,489,000.00 | 105,769,000.00 |
| 120009 | Бусад орлого | 21,000,000.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,265,628,529.00** | **3,655,442,914.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,262,207,200.00 | 1,984,606,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,262,207,200.00 | 1,984,606,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,003,421,329.00 | 1,670,836,414.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 40,265,820.00 | 34,524,960.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 907,658,149.00 | 1,613,925,454.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 55,497,360.00 | 22,386,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,324,435,929.00** | **3,743,042,914.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,324,435,929.00** | **3,743,042,914.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,057,942,900.87** | **2,219,640,848.70** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,045,566,673.83 | 1,786,527,221.67 |
| 210101 | Үндсэн цалин | 591,907,370.37 | 726,225,249.53 |
| 210102 | Нэмэгдэл | 343,396,303.25 | 578,163,630.14 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 88,482,503.69 | 213,765,487.05 |
| 210104 | Урамшуулал | 21,780,496.52 | 268,372,854.95 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 130,352,689.09 | 222,791,466.32 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 89,022,876.48 | 151,502,135.47 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,384,452.45 | 17,885,610.76 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,291,033.70 | 8,942,857.38 |

| | | | |
|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,052,500.30 | 8,892,231.93 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20,601,826.16 | 35,568,630.78 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 29,875,852.06 | 14,470,544.23 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,897,497.38 | 6,173,751.28 |
| 210302 | Түлш, халаалт | 19,350,851.68 | 6,661,385.95 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,627,503.00 | 1,635,407.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 30,581,259.08 | 61,463,316.48 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,787,200.00 | 24,710,360.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,685,950.00 | 20,132,256.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,773,399.08 | 3,554,800.48 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 268,500.00 | 120,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,066,210.00 | 12,945,900.00 |
| **2105** | **Норматив зардал** | 26,622,825.00 | 81,173,100.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,457,425.00 | 2,417,340.00 |
| 210502 | Хоол, хүнс | 24,315,400.00 | 72,255,760.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 850,000.00 | 6,500,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,185,000.00 | 4,213,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,205,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 1,980,000.00 | 4,213,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,584,000.00 | 7,896,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,584,000.00 | 7,896,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 34,297,464.81 | 41,105,700.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 31,152,510.81 | 38,589,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 900,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 337,000.00 | 1,229,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 125,004.00 | 258,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 823,800.00 | 800,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 959,150.00 | 229,600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 753,877,137.00 | - |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 734,739,937.00 | - |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 19,137,200.00 | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **266,493,028.13** | **1,523,402,065.30** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 221,913,455.00 | 1,478,841,710.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | - | 1,227,000,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 15,841,723.00 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 168,830,850.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 206,071,732.00 | 83,010,860.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 44,579,573.13 | 44,560,355.30 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 44,579,573.13 | 44,560,355.30 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **17,681,600.00** | **18,169,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **-** | **14,169,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **14,169,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 14,169,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 14,169,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-** | **(14,169,000.00)** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 17,681,600.00 | 4,000,000.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 21,241,600.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 21,241,600.00 | 25,241,600.00 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 952,451,564.01 | 140,421,970.81 | 1,092,873,534.82 |
| D01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 952,451,564.01 | 140,421,970.81 | 1,092,873,534.82 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 952,451,564.01 | 140,421,970.81 | 1,092,873,534.82 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | 93,421,870.84 | 93,421,870.84 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 952,451,564.01 | 233,843,841.65 | 1,186,295,405.66 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,055,300,500.00 | 2,027,315,144.70 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,055,300,500.00 | 2,027,315,144.70 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,877,027,200.00 | 1,849,043,434.70 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,528,666,500.00 | 1,523,816,947.67 |
| 210101 | Үндсэн цалин | 751,947,500.00 | 726,225,249.53 |
| 210102 | Нэмэгдэл | 458,816,400.00 | 463,463,144.14 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 170,287,000.00 | 213,765,487.05 |
| 210104 | Урамшуулал | 147,615,600.00 | 120,363,066.95 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 193,246,900.00 | 190,195,986.32 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 132,328,100.00 | 129,277,186.32 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 15,229,700.00 | 15,229,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,614,900.00 | 7,614,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 7,614,900.00 | 7,614,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 30,459,300.00 | 30,459,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 24,288,500.00 | 14,470,544.23 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,300,000.00 | 6,173,751.28 |
| 210302 | Түлш, халаалт | 13,984,300.00 | 6,661,385.95 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,004,200.00 | 1,635,407.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 34,797,300.00 | 34,317,616.48 |
| 210401 | Бичиг хэрэг | 9,962,000.00 | 9,717,760.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,047,100.00 | 9,977,656.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,613,200.00 | 2,604,800.48 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 276,400.00 | 120,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 11,898,600.00 | 11,897,400.00 |
| **2105** | **Норматив зардал** | 42,494,000.00 | 37,048,140.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,420,000.00 | 2,417,340.00 |
| 210502 | Хоол, хүнс | 33,500,000.00 | 28,130,800.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 6,574,000.00 | 6,500,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 18,447,400.00 | 18,382,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 14,194,300.00 | 14,169,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,253,100.00 | 4,213,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,943,000.00 | 6,920,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,943,000.00 | 6,920,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 28,143,600.00 | 23,891,700.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 24,600,000.00 | 21,375,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,331,200.00 | 1,229,100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 330,000.00 | 258,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 82,300.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 808,100.00 | 800,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 992,000.00 | 229,600.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 178,273,300.00 | 178,271,710.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 178,273,300.00 | 178,271,710.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 168,830,900.00 | 168,830,850.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 9,442,400.00 | 9,440,860.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,055,300,500.00 | 2,027,315,144.70 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,984,606,500.00 | 1,965,343,004.70 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,984,606,500.00 | 1,965,343,004.70 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 70,694,000.00 | 61,972,140.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 70,694,000.00 | 61,972,140.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | **21,241,600.00** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | **25,241,600.00** |

### 2.5.1 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,670,836,414.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,670,836,414.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 384,766,414.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 262,710,274.00 |
| 210102 | Нэмэгдэл | 114,700,486.00 |
| 210104 | Урамшуулал | 148,009,788.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 32,595,480.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,224,949.15 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,655,910.76 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,327,957.38 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,277,331.93 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,109,330.78 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 27,145,700.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 14,992,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,154,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 950,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,048,500.00 |
| **2105** | **Норматив зардал** | 44,124,960.00 |
| 210502 | Хоол, хүнс | 44,124,960.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 976,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 976,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 17,214,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 17,214,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,286,070,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,286,070,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 1,227,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 59,070,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,670,836,414.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,670,836,414.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 34,524,960.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,613,925,454.00 |

| | | |
|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 22,386,000.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **-** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 117,415.2 мянган төгрөгийн 4 алдаа[1] илэрснээс аудитын явцад 117,415.2 мянган төгрөгийн алдааг залруулсан.

*Залруулсан алдаа:*

- Мөнгөн гүйлгээний тайлан дахь биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлыг үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн худалдан авсан хөрөнгийн дүнтэй тулган баталгаажуулахад 27,169.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Мөнгөн гүйлгээний тайлангийн мэдээлэл, технологийн үйлчилгээний зардлын дүнг санхүүгийн үр дүнгийн тайлангийн уг зардалтай тулган баталгаажуулахад 800.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан
- Өглөгийн тодруулга тайлангийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийн дүнг мөнгөн гүйлгээний тайлангийн уг дүнтэй тулган баталгаажуулахад 65,588.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Өглөгийн тодруулга тайлангийн хүн амын орлогын албан татварын өглөгийн дүнг мөнгөн гүйлгээний тайлангийн уг дүнтэй тулган баталгаажуулахад 23,857.7 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан нь УСНББОУС 1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" 20 дугаар зүйлийн 20.2 "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул 117,415.2 мянган төгрөгөөр залруулав.

Аудитаар 5 зөрчил[2] илэрсэнд зөвлөмж, албан шаардлага өгсөн.

### 3.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогүй.

### 3.2 Албан шаардлага

<u>*Илрүүлэлт-1*</u>*:* Тайлант онд цалингийн зардлаас 1,300.0 мянган төгрөгийн балансын урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 16 дугаар зүйлийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцээгүй байна.

<u>*Шийдвэрлэсэн нь :*</u> Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх,төлбөрийн акт тогтоох журам"-ын дагуу албан шаардлага хүргүүлэх

<u>*Илрүүлэлт-2*</u> Тайлант хугацаанд нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 1,000.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйлс албан хаагчдад тараасан:

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дугаар зүйлийн 24.7-д "Төсвийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд болон орон нутагт ногдох хөрөнгийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 3.1.2-т заасан нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр, тэдгээртэй адилтгах аливаа өдөрлөгт зориулж зарцуулахыг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь :* Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх,төлбөрийн акт тогтоох журам"-ын дагуу албан шаардлага хүргүүлэх

*Илрүүлэлт-3:* Тайлант хугацаанд нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 1,299.4 мянган төгрөгийн шагналын зүйлс худалдан авч албан хаагчдад тараасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дугаар зүйлийн 24.7-д "Төсвийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд болон орон нутагт ногдох хөрөнгийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 3.1.2-т заасан нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр, тэдгээртэй адилтгах аливаа өдөрлөгт зориулж зарцуулахыг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь :* Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх,төлбөрийн акт тогтоох журам"-ын дагуу албан шаардлага хүргүүлэх

*Илрүүлэлт-4:* Тайлант онд нэмэлт санхүүжилтийн зардлаас урлагийн тоглолтын үйлчилгээний төлбөрт 1,000.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 16 дугаар зүйлийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д "хуулиар зөвшөөрөөгүй бусад" гэж заасантай тус тус нийцэхгүй байна

*Шийдвэрлэсэн нь :* Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх,төлбөрийн акт тогтоох журам"-ын дагуу албан шаардлага хүргүүлэх

*Илрүүлэлт-5:* Тайлант хугацаанд хоолны зардалд 72,255.7 мянган төгрөг зарцуулахдаа худалдан авах ажиллагаа зарлаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д "хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д "ерөнхий гэрээний арга" гэж захиалагчийн тодорхой хугацаанд давтамжтай худалдан авдаг, эсхүл байнгын хэрэгцээтэй бараа, үйлчилгээний нэгж дээд үнэ болон бусад нөхцөлийг тогтоосон ерөнхий гэрээг нэг ба түүнээс дээш оролцогчтой байгуулж, цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авахыг" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь :* Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх,төлбөрийн акт тогтоох журам"-ын дагуу албан шаардлага хүргүүлэх

**3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

*Илрүүлэлт-1:* Тайлант онд цалингийн зардлаас 18,500.0 мянган төгрөгийн ахмадын сан байгуулсан боловч 2024 оны төсвийн төсөлд тусгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 16 дугаар зүйлийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай

байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих",16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Төсвийн хүрээний мэдэгдлийг бодитой төлөвлөж ажиллах.

*Илрүүлэлт-2:* Бараа, үйлчилгээний худалдан авалтын төлбөрийн Е баримтын зардлыг барааны нэр төрөл, тоо ширхгээр гаргуулаагүй, бөөн дүнгээр шивүүлж, анхан шатны баримтад хавсарсан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-д "анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, татварын тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх" гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Бараа, үйлчилгээ худалдан авалт хийх тухай бүрд борлуулагчийн хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг кассын машинаас хэвлүүлэн авч анхан шатны баримтад хавсаргаж ажиллах.

*Илрүүлэлт-3:* Бага үнэтэй түргэн элэгдэх зардлаас 5,814,700 төгрөгөөр ус буцалгагч, уртасгагч залгуур, массажны аппарат худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтайгаар зарцуулан ажиллах, хэрэгцээ шаардлагагүй хөрөнгө бэлтгэхгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Д.д | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Мөнгөн гүйлгээний тайлан дахь биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлыг үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн худалдан авсан хөрөнгийн дүнтэй тулган баталгаажуулахад 27,169.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан | 1 | 27,169.0 | 1 | 27,169.0 | - | - | 1 | 27,169.0 | - | - | - | - |
| 2 | Мөнгөн гүйлгээний тайлангийн мэдээлэл, технологийн үйлчилгээний зардлын дүнг санхүүгийн үр дүнгийн тайлангийн уг зардалтай тулган баталгаажуулахад 800.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан | 1 | 800.0 | 1 | 800.0 | | | 1 | 800.0 | | | | |
| 3 | Өглөгийн тодруулга тайлангийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийн дүнг мөнгөн гүйлгээний тайлангийн уг дүнтэй тулган баталгаажуулахад 65,588.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан, | 1 | 65,588.5 | 1 | 65,588.5 | | | 1 | 65,588.5 | | | | |
| 4 | Өглөгийн тодруулга тайлангийн хүн амын орлогын албан татварын өглөгийн дүнг мөнгөн гүйлгээний тайлангийн уг дүнтэй тулган баталгаажуулахад 23,857.7 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан | 1 | 23,857.7 | 1 | 23,857.7 | | | 1 | 23,857.7 | | | | |
| | Дүн | **4** | **117,415.2** | **4** | **117,415.2** | **-** | **-** | **4** | **117,415.2** | **-** | **-** | **-** | **-** |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Д.д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Тайлант онд цалингийн зардлаас 18,500,0 мянган төгрөгийн ахмадын сан байгуулсан боловч 2024 оны төсвийн төсөлд тусгаагүй. | 1 | 18,500.0 | | | | | 1 | 18,500.0 | | | | |
| 2 | Бараа, үйлчилгээний худалдан авалтын төлбөрийн Е баримтын зардлыг барааны нэр төрөл, тоо ширхгээр гаргуулаагүй, бөөн дүнгээр шивүүлж, анхан шатны баримтад хавсарсан байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| 3 | Бага үнэтэй түргэн элэгдэх зардлаас 5,814,7 мянган төгрөгөөр ус буцалгагч, уртасгагч залгуур, массажны аппарат худалдан авсан. | 1 | 5,814.7 | | | | | 1 | 5,814.7 | | | | |
| 4 | Нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн 61,972,1 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлогыг батлуулаагүй шууд зарцуулсан. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| 5 | Тайлант онд цалингийн зардлаас 1,300.0 мянган төгрөгийн балансын урамшуулал олгосон. | 1 | 1,300.0 | | | 1 | 1,300.0 | | | | | | |
| | **Дүн** | **5** | **25,614.7** | **-** | **-** | **1** | **1,300.0** | **4** | **24,314.7** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Д.д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Тайлант хугацаанд нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 1,000.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйлс албан хаагчдад тараасан | 1 | 1,000.0 | | | 1 | 1,000.0 | | |
| 2 | Тайлант хугацаанд нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 1,299.4 төгрөгийн шагналын зүйлс худалдан авч албан хаагчдад тараасан | 1 | 1,299.40 | | | 1 | 1,299.40 | | |
| 3 | Тайлант онд нэмэлт санхүүжилтийн зардлаас урлагийн тоглолтын үйлчилгээний төлбөрт 1,000.0 мянган төгрөг зарцуулсан | 1 | 1,000.0 | | | 1 | 1,000.0 | | |
| 4 | Тайлант хугацаанд хоолны зардалд 72,255.7 мянган төгрөг зарцуулахдаа худалдан авах ажиллагаа зарлаагүй байна | 1 | - | | | 1 | - | | |
| | **Дүн** | **4** | **3,299.4** | **-** | **-** | **4** | **3,299.4** | **-** | **-** |